



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 8/690

Арвайхээр

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйл 30.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нэр өөрчлөх тухай” 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хужирт эрдэс баялаг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хужирт эрдэс баялаг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйлчилгээний үнэ тариф тогтоох талаар санал гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Т.Ариунболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх  
Байгал орчин, аялал жуулчлалын газрын дарга  
Гишүүдэд: Д.Уранцэцэг -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв,  
санхүү хариуцсан мэргэжилтэн

А.Баяндүүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн  
өмчийн газрын Хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт,  
хөрөнгийн лавлагаа, бүртгэл мэдээллийн нэгдсэн  
программ хариуцсан мэргэжилтэн

Ж.Шижээ -“Хужирт эрдэс баялаг” орон нутгийн өмчит аж  
ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий захирал  
(зөвшилцсөнөөр)

3. Цэцэгмаа -Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын  
Байгаль орчны хяналтын улсын байцаагч  
Ж.Баянжаргал -“Ананд хужирт” рашаан сувилалын гүйцэтгэх  
захирал (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: С.Ганчимэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. “Хужирт эрдэс баялаг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, үйлчилгээний үнэ тариф тогтоох саналыг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Ариунболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011101310